

4. ЗӨГИЙН АРЧИЛГАА МАЛЛАГААНЫ ХАВРЫН МЕНЕЖМЕНТ (3-5 ДУГААР САР)




4-1. Зөгийн бүлийг өвөлжөөнөөс гаргахын өмнөх бэлтгэл ажил	75
4-1-1. Зөгий тавих газраа сонгох, бэлтгэх	75
4-1-2. Цэвэрлэж халдваргүйтгэсэн үүр хайрцаг, дэр, цаваг давууг бэлтгэх	75
4-1-3. Уурагт тэжээлийн нөөц бэлтгэх	76
4-1-4. Варроа хачгийн эмийн нөөц бэлтгэх:	77
4-2. Зөгийн бүлийг өвөлжөөнөөс гаргах болон нэн даруй хийх арчилгаа	77
4-2-1. Зөгийн бүлийг өвөлжөөнөөс хэзээ гаргах вэ?	77
4-2-2. Өвөлжсөн үүр хайрцгийг солих, цэвэрлэх	78
4-2-3. Жаазыг цөөлж зөгийн нягтаршлыг нэмэгдүүлэх (Зөгийг шахах)	78
4-2-4. Зөгийн бүлд идэвхжүүлэх уусмал, уурагт тэжээл өгөх	79
4-2-5. Варроа хачгийн эмийг хэрэглэх, үр дүнг шалгах	81
4-3. Өвөлжөөнөөс гарсан даруйд үүсэж болзошгүй бэрхшээл, авах арга хэмжээ	82
4-3-1. Өвөлжөөнөөс эх зөгийгүй бүл гарч ирэх, авах арга хэмжээ	82
4-3-2. Эх зөгийтэй боловч ажилчин зөгийн тоо хэт цөөхөн байх, авах арга хэмжээ	82
4-3-3. Өвөлжөөнөөс сахарын тэжээлийн нөөц бүрэн дуусч гарч ирэх, авах арга хэмжээ	82
4-3-4. Өвөлжөөнөөс гарсан эх зөгий өндөглөхгүй байх, авах арга хэмжээ	82
4-3-5. Өвөлжөөнөөс гарснаас хойших нэг сарын хугацаанд хийх арчилгаа	83
4-4. Өвөлжөөнөөс гарснаас хойш нэг сарын дараагаас эхлэн хийх арчилгаа	84
4-4-1. Шинээр өндөглүүлэх жааз нэмэх	85
4-4-2. Эх зөгийд өндөглөх ташаалавч нэмж өгөх	87
4-4-3. Зөгий сүрэглэх ба сэргийлэх арга хэмжээ	87

4-1. Зөгийн бүлийг өвөлжөөнөөс гаргахын өмнөх бэлтгэл ажил

4-1-1. Зөгий тавих газраа сонгох, бэлтгэх

- Зөгийн бүлийг өвөлжөөнөөс гаргаж тавих газар нь нар ээвэр, нөмөр дулаан байх
- Зөгий тавих газрын эргэн тойрны нойтон цас, хунгарыг цэвэрлэх
- Хаврын шар ус, газрын чийгнээс хамгаалж үүр хайрцгийг газраас бага зэрэг хөндий байлгах зорилгоор ивээс, тавиур зэргийг бэлтгэх
- Зөгийн бүлийг гэнэтийн хүйтрэлтээс хамгаалах зорилгоор нэг бүрчлэн эсвэл хэсэг бүлгээр нь (5-6 бүлээр) ойр зайтай эгнүүлэн тавьж хучих хучлага бэлтгэх
- Эсвэл араараа битүү нар ээвэр байх саравч бэлтгэх
- Услуурыг аль болох зөгийд ойрхон жижиг жижиг саванд хийж тавихаар тооцох
- Суурин газрын хувьд зөгий очиж эрсдэж болзошгүй химийн бодис, муудаж гашилсан зүйл, бохирын онгорхой нүх зэргийг урьдчилан устгаж цэгцэлсэн байх



Талбай бэлтгэх



Хучлага бэлтгэх



Бохир орчин

4-1-2. Цэвэрлэж халдваргүйтгэсэн үүр хайрцаг, дэр, цаваг давууг бэлтгэх

Эвдэрсэн үүр хайрцаг, жааз, хашлага самбар, идүүрийг засаж сэлбэх, цаваг даавууг угааж чанаж цэвэрлэх, шинээр дэр, даавуу оёж бэлтгэх гэх мэт ажлуудыг намар, өвөл, хаврын туршид урьдчилан төлөвлөж, хийж занших хэрэгтэй.

- Зөгийтэй өвөлжсөн үүр хайрцгийг цэвэрлэж халдваргүйтгэсэн, хуурай хайрцгаар зайлшгүй солих шаардлагатай тул хүрэлцэхүйц хэмжээгээр бэлтгэнэ.
- Зөгийтэй өвөлжсөн үүр хайрцаг, жааз, хашлага самбар, дэр, цаваг даавууг сольж суларсан даруйд цэвэрлэж халдваргүйтгэх бэлтгэлээ хийсэн байна.



4-1-3. Уурагт тэжээлийн нөөц бэлтгэх

Хаврын уурагт тэжээл нь зөгий өвөлжөөнөөс гарснаас хойш анхны цэцгийн тоосыг цуглуулж ирэх хүртэлх хугацаанд шаардлагатай байдаг. Уурагт тэжээлээр хангагдсан ажилчин зөгий сүүнцэр үйлдвэрлэж түүгээрээ авгалдайгаа тэжээдэг. Дараах байдлаар уурагт тэжээлийг бэлтгэж болно. Үүнд:

- Зун, намрын улиралд цэцгийн тоосормог бүхий жааз нөөцлөөд хавар ашиглах нь хамгийн чанартай тэжээл бөгөөд бас зардал багатай арга юм. Цэвэрхэн сэрүүн орчинд хөгцөрч, мөөгөнцөртүүлэхгүйгээр хадгалах шаардлагатай. Өөр зөгийн аж ахуйгаас тоосормогтой жааз авч ашиглаж болохгүй буюу зөгийн халдварт өвчин авч ирэх эрсдэлтэй байдаг. Өөр аж ахуйгаас цэцгийн тоосормог авч ашиглах нь түүгээр өвчин дамжих эрсдэлтэй байдгийг анхаарах хэрэгтэй.
- Зун, намрын улиралд хурааж нөөцөлсөн цэцгийн тоосормог болон нунтаг сахар (сахарын пудр)-ыг 2:1 харьцаагаар зөгийн балаар өтгөн зуурч уурагт тэжээл бэлтгэж болно. Цэцгийн тоосыг хураасан даруйдаа дэлгэж чийг багатай болгоод хөлдөөж хадгалж болно.
- Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн уурагт тэжээлийг худалдаж авах. Энэ төрлийн тэжээл нь харьцангуй үнэ өндөртэй байдаг. Мөн тухайн тэжээлд зөгий хэр зэрэг дуртай байгаа болон зөгийн бүлийг эрт хүч авахуулж чадаж буй зэргийг сайтар ажиглах хэрэгтэйг зөвлөж байна.



Анхааруулга: Аливаа нэмэгдэл тэжээлийг хэрэглэхийн өмнө заавартай сайтар танилцах нь чухал юм. Уурагт тэжээл болон кэнди нь зөгийн нэмэгдэл тэжээл боловч зориулалтаараа ялгаатай байдаг.

- Уурагт тэжээл нь зөгийн бүлийн хөгжлийг (өндөг, үрвэлдэйн бойжилтыг) дэмждэг. Иймээс шаардлагатай бол хавраас намрын улиралд зөгийн бүлд нэмэгдэл тэжээл болгон өгдөг.
- Кэнди (чихэр) нь нүүр ус ихтэй учир зөгийн энергийн эх үүсвэр болдог. Иймээс шаардлагатай бол зөгийн бүл өвөлжих явцад нэмэгдэл тэжээл болгон өгдөг.
- Кэнди (чихэр) + витамин + эмийн бодис гэсэн найрлагатай болон хаврын улиралд хэрэглэнэ гэсэн заалттай байдаг.

4-1-4. Варроа хачгийн эмийн нөөц бэлтгэх:

Зөгийн аж ахуйн хаврын бэлтгэл ажлын нэг бол варроа хачгийн эсрэг эмийг бэлтгэх явдал бөгөөд дараах зүйлд анхаарах шаардлагатай байдаг.

- Өмнөх намар хэрэглэсэн эмээ өөр төрлийн (үйлчлэгч бодис өөр байх) эмээр сольж хэрэглэх. Энэ нь эмэнд дасал болохоос сэргийлдэг.
- Хачгийн эсрэг эм сонгохдоо гэрээт малын эмчээс асууж зөвлөлдөөд эмийн төрөл, шаардлагатай тоо хэмжээг тогтооно.
- Хугацаа нь дууссан, хэрэглэх арга тун нь ойлгомжгүй зэрэг эмийг хэрэглэж болохгүй.

Хаврын хачгийн эмийн эмчилгээтэй зэрэгцүүлэн эмийн бус эмчилгээ (Хачгийн занга бэлтгэн ашиглах)-г хийх нь илүү үр дүнтэй байдаг. Хачгийн зангыг хавраас намрыг дуустал байнга ашиглах нь варроа хачгийн халдварыг нэмэгдүүлэхгүй байх үр дүнтэй арга болдог. Энэ аргын тухай Варроа хачгийн эсрэг эмийн бус эмчилгээ хэсэг (9-5-4)-ээс уншина уу.

4-2. Зөгийн бүлийг өвөлжөөнөөс гаргах болон нэн даруй хийх арчилгаа

4-2-1. Зөгийн бүлийг өвөлжөөнөөс хэзээ гаргах вэ?

Зөгийн бүлийг өвөлжөөнөөс гаргах хугацаа нь газар зүйн байршил, тухайн жилийн цаг агаар, өвөлжөөний байрны нөхцөл зэргээс шалтгаалж зөрүүтэй байж болох ч дараах ерөнхий зүйлүүдийг анхаарах шаардлагатай.

- Гадаа орчны температур шөнөдөө тогтмол $-5-7^{\circ}\text{C}$ –ээс хэтрэхгүй болж дулаарсан байх нь тохиромжтой. Цаг уурын олон жилийн статистик мэдээнээс харахад Монгол орны төвийн бүс нутагт дунджаар 3 дугаар сарын 17-20-ны өдрүүдээс хойш дээрх хэм бүртгэгддэггүй байна. Энэ нь 3 дугаар сарын сүүлийн 10 хоногт зөгийг өвөлжөөнөөс гаргах нь тохиромжтойг харуулж байна.
- Өвөлжиж буй зөгийн бүлийн тэжээлийн хүрэлцээ ямар байгааг 3 дугаар сарын эхэнд шалгах шаардлагатай. Хэрэв тэжээл дууссан, эсвэл дахин 3 долоо хоногт хүрэлцэхээргүй бол нунтагласан элсэн чихрийг

зөгийн балаар өтгөн зуурч кэнди бэлтгэж тэжээгээд зөгийн бүлийг өвөлжөөнөөс гаргаж болно.

- Агаарын урсгал муутай эсвэл цэвэрлэгээ халдваргүйтгэл муу хийсэн өвөлжөөний байранд хаврын урь орох тусам чийг ихтэй болох, мөөгөнцөр үүсдэг. Энэ тохиолдолд зөгийн бүлийг аль болох эрт гаргах шаардлага үүсдэг.
- Зөгийн бүлийг нар ээсэн дулаан өдрийг сонгож өвөлжөөнөөс гаргахыг зөвлөж байна.


4-2-2. Өвөлжсөн үүр хайрцгийг солих, цэвэрлэх

Зөгийтэй өвөлжсөн модон үүр хайрцаг нь өвлийн туршид чийгийг өөртөө шингээсэн байдаг. Заримдаа ийм үүр хайрцаг нь бидэнд цэвэрхэн мэт харагдавч зөгийд таагүй байдал үүсгэж болзошгүй тул солих шаардлагатай.

- Урьдчилан цэвэрлэж, халдваргүйтгэж бэлтгэсэн корпус, ул мод, хүзүүвч, таг, идүүр, хашлага самбар, дэр, цаваг даавуу зэргийг аль нэгийг нь үлдээлгүйгээр бүгдийг солих хэрэгтэй.
- Өндөглөөд эхэлсэн, өндөглөхөөр цэвэрлэсэн, сахарын тэжээлтэй (1-2 ширхэг) жаазнуудаас бусад өвөлжсөн жаазнуудыг авна.
- Өвөлжсөн үүр хайрцаг түүний дагалдах бүх зүйлийг тусад нь байлгаж 3-2-1-т заасан аргаар цэвэрлэж халдваргүйтгэнэ.

4-2-3. Жаазыг цөөлж зөгийн нягтаршлыг нэмэгдүүлэх (Зөгийг шахах)

Өвөлжөөнөөс гарсан бүлийн дунд талын буюу бараг тэжээлгүй болоод өндөглөхөд бэлтгэгдэж байгаа эсвэл өндөглөөд эхэлчихсэн гурав орчим жаазыг (бүлийн хүчнээс шалтгаалж +1 жааз) хоёр талаас нь хашлага самбараар хашиж үлдээнэ.



4-2-4. Зөгийн бүлд идэвхжүүлэх уусмал, уурагт тэжээл өгөх

Жаазыг цөөлж шахсан зөгийн бүлийг өвөлжөөнөөс гарсан даруйд 2-3 өдөрт нэг удаа 150 мл, 1:1 шингэн сахарын уусмалаар тэжээнэ. Энэхүү тэжээл нь тэжээл дутагдсан гэж өгч буй тэжээл биш буюу цэцгийн шүүсийг орлуулсан уусмал бөгөөд зөгийн бүлд “хавар ирлээ” гэдгийг мэдэгдэж эх зөгийн өндөглөлтийг идэвхжүүлэх зорилготой юм. Мөн өндөглөлтийг идэвхжүүлэх, авгалдайг тэжээлээр хангах зорилгоор тоосормогт болон тоосормог орлуулах тэжээлээр (эрүүл, ариун тэжээл) тэжээнэ.

Сахарын уусмал болон
нөөцөлсөн тоосормогт
тэжээлээр зөгийг
идэвхжүүлнэ.



Идэвхжүүлэх сахарын уусмал:
(ус болон сахар = 1:1)
150 мл-ээр 2-3 өдөрт 1 удаа тэжээнэ.

Уурагт тэжээл:

Энэ гарын авлагын 4-1-3-т бичсэний дагуу
уурагт тэжээлийн нөөц бэлтгээд зөгий
цэцгийн тоос зөөж авч ирэх хүртэл
тэжээнэ.



Аль болохоор жаазны нэг
захаас нөгөө зах хүртэл
дүүрэн өндөглүүлнэ.



Өндөглөж эхэлнэ!



Монголын нөхцөлд зөгийн бүл анхны цэцгийн тоос, амтат шүүсийг бургаснаас авдаг. Энэ хүртэл тэдэнд уурагт тэжээл шаардлагатай юм. Зөгийн бүл байгаа газраас 1~2 км тойрог дотор бургас, яргуй, бүйлс гэх мэт хавар эрт цэцэглэдэг ургамлуудаас авч буй амтат шүүс болон тоосны хэмжээг ажиглан, идэвхжүүлэх тэжээлээ тохируулж өгнө. Энэ үед ойрхон үзлэг хийж бүлийн тэжээлийн нөөцийг шалгаж өндөглөлтийг дэмжихэд анхаарах нь чухал юм.

Хавар байгалийн ургамлаас тоос зөөх хүртэл зөгийн бүлийг уургаар дутагдуулснаас өндөгийг тэжээх сүүнцэр бий болохгүй болж улмаар бүл сүйрэх тохиолдол байсаар байгааг анхаарах нь чухал юм.

4-2-5. Варроа хачгийн эмийг хэрэглэх, үр дүнг шалгах

Варроа хачгийн эсрэг хэрэглэдэг олон хэлбэрийн (зүүдэг тууз, шүршдэг шингэн, утаж мананцаржуулах шингэн гэх мэт) эм байдгаас хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь зүүдэг тууз юм.

Эм хэрэглэх үедээ дараах зүйлсийг анхаарна уу:

- ✓ Эмийг зааврын дагуу хэрэглэнэ.
- ✓ Эм бол хор учраас маш болгоомжтой хэрэглэх шаардлагатай. Тухайлбал, хэрэглэх хугацаа дууссан эмийг ашиглаж болохгүй. Мөн хэрэглээгүй үлдсэн эмээ сайтар битүүмжлээд хэрэглэх зааварт заасан нөхцөлд хадгална.
- ✓ Хэрэглэх заавартай танилцахад ойлгомжгүй байвал малын эмчээс заавал зөвлөгөө аваарай.
- ✓ Найруулж шүршдэг шингэн хэлбэрийн эмийн тунг тохируулахад хэцүү тул эмэнд дасал үүсэхээс сэргийлж хэрэглэхгүй байхыг зөвлөж байна.
- ✓ Намар хэрэглэсэн эмийг хавар хэрэглэхгүй байдлаар сольж хэрэглэх
- ✓ Өвөлжсөн хачиг нь хаалттай үрвэлдэйд шимэгчлэн үржих учир хаалттай үрвэлдэй олноор бий болохоос өмнө хачигны эмчилгээг хийх шаардлагатай.
- ✓ Эмчилгээний үр дүнг заавал тооцож үхсэн хачгийг шалгах хэрэгтэй. Үүний тулд цөөн бүлийн ул модон дээр цагаан цаас дэвсэж үүн дээр эмчилгээ хийснээс 24 цагаас багагүй хугацааны дараа үхсэн хачгийн олон, цөөн байгааг шалгаарай.
- ✓ Эмийн зааварт заасан хугацаанд хэрэглэсэн боловч зөгийн биед хачиг харагдаж байвал малын эмчтэй зөвлөлдсөний үндсэн дээр туузан хэлбэрийн эмийг дахин ашиглаж болох юм.

Эмчилгээний үр дүнг шалгах нь тухайн эмийн үйлчилгээний идэвх, давтан эмчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлж өгдөг.

Түр хүлээнэ үү!
Та хэрэглэх гэж байгаа
эмийнхээ тухай мэдэх үү?



Эмчилгээний үр дүнг малын эмчтэй хамт тодорхойлох.

4-3. Өвөлжөөнөөс гарсан даруйд үүсэж болзошгүй бэрхшээл, авах арга хэмжээ

4-3-1. Өвөлжөөнөөс эх зөгийгүй бүл гарч ирэх, авах арга хэмжээ

Өвөлжөөнөөс эх зөгийгүй бүл гарч ирвэл эх зөгийтэй боловч сул хүчтэй бүлтэй нийлүүлнэ. Зөгийн бүлийг өвөлжөөнөөс гаргасан өдрөө үзлэг хийж эхгүй болсон бүлийг нийлүүлэх нь зөгий байршлаа тогтоогоогүй, буцаж нисэх зөн байхгүй үе учир хялбар байдаг. Энэ тохиолдолд нийлүүлж буй бүлүүдийг зөвхөн хашлага самбараар тусгаарлаж болно. Хаврын хэтэрхий сул бүлийг сонингийн аргаар нийлүүлэхэд нэвтэрч чадахгүй бөөнөөр хорогдох тохиолдол байдаг.

4-3-2. Эх зөгийтэй боловч ажилчин зөгийн тоо хэт цөөхөн байх, авах арга хэмжээ

Энэ тохиолдолд нийлүүлэх өөр эхгүй бүл байхгүй бол бусад бүлүүдээс хамгийн сул хүчтэй бүлийг сонгож нэг үүр хайрцганд хоёр бүл байлгах аргыг ашиглана. Үүний тулд бүлүүдийг хооронд нь эх тусгаарлагч тороор хашина. Эх тусгаарлах торны хажуу завсраар эх зөгий гарахааргүй зай завсаргүй болгох хэрэгтэй. Ингэж эх зөгий нь тусдаа, ажлын зөгий нийлсэн байдлаар хэсэг хугацаанд маллахад тус бүртээ хүч нь нэмэгдэх ба үүний дараа тусад нь биеэ даасан бүл болгоно.

4-3-3. Өвөлжөөнөөс сахарын тэжээлийн нөөц бүрэн дуусч гарч ирэх, авах арга хэмжээ

Бүх бүл жигд тэжээлийн нөөцөө дуусаад гарч ирэх нь элбэг тохиолддог. Энэ тохиолдолд бүлүүдийг 1:1 харьцаатай сахарын уусмалаар тэжээх шаардлагатай. Идүүрт хийсэн сахарын уусмалаа завсар гаргасан хашлага самбарын гадна талд нь тавьж өгөөрэй.

Ингээд сахарын тэжээлтэй жаазнууд бий болгоод завсартай хашлага самбарын гадна гаргаж, өндөглүүлэх жаазыг хашлага самбарын дунд байрлуулна.

4-3-4. Өвөлжөөнөөс гарсан эх зөгий өндөглөхгүй байх, авах арга хэмжээ

Намар эх зөгий солигдоод хээл авч амжаагүй өвөлжөөнд орох, хэт хуучин эх зөгий өвөлжих, хөл гэмтэх гэх мэт шалтгаанаар өвөлжөөнөөс гарсан эх зөгий өндөглөхгүй байдаг. Зөгийчин үүнийг анзааралгүй цаг алдах явдал байдаг.

Иймээс өндөглөлт эхлэхгүй эсвэл маш бага өндөглөж байгаа бүлийн эх зөгийг сайтар ажиглана. Ийм бүлийн эхийг устгаад цаг алдалгүй бусад бүлтэй нийлүүлэх арга хэмжээ авах ба цаг алдвал ажилчин зөгий асмарч өндөглөж эхлэх эрсдэл үүсдэг. Нэг ташаалавчинд 3-4 өндөг харагдах, сүүнцэрээр тэжээгдсэн авгалдай байхгүй байх шинж тэмдэг нь ажилчин зөгий асмарч өндөглөж буй шинж тэмдэг юм. Энэ тохиолдолд зөгийтэй жаазнуудыг авч зөөврийн хайрцганд хийгээд үүр хайрцагнаас алс зайд очиж бүх зөгийг өвстэй газар сэгсэрч асмарсан зөгийг үлдээнэ. Ингээд үүр хайрцгандаа буцаж ирсэн бүлийг өөр бүлтэй нийлүүлэх арга хэмжээ авна.



Эхгүй хэт цөөн зөгийтэй
бүлийг хашлага
самбараар нийлүүлэх



Эхгүй боловч харьцангуй олон
зөгийтэй бүлийг сонингийн
аргаар нийлүүлнэ



Эхтэй боловч хэт цөөн
зөгийтэй бүлийг хүчтэй
бүлтэй нийлүүлэх

4-3-5. Өвөлжөөнөөс гарснаас хойших нэг сарын хугацаанд хийх арчилгаа

Анхны идэвхжүүлэх тэжээлээс хойш нэг сарын дотор тухайн үеийн байдлаас шалтгаалах боловч аль болох шинэ жааз нэмэхгүй байх нь хамгийн чухал. Энэ хугацаанд хуучин зөгий үхэж аажмаар цөөрнө. Өнгөц харахад зөгийн тоо нэмэгдсэн мэт харагдах боловч түүний дараа олон хуучин зөгий үхэж зөгийн тоо цөөрөх учраас үнэндээ бага зэрэг л нэмэгдсэн байдаг. Шинэ жааз нэмж хийснээр зөгийн нягтаршил буурч үүрэн доторх температурыг тогтмол хадгалах боломжгүй болж өндөг үрвэлдэй ихээр үхэх тохиолдол байдаг.

Зөгий ихтэй байснаар эх зөгий жаазны нэг захаас нөгөө зах хүртэл битүү өндөглөнө (Зураг 4-3-5).

Нэг өнцгөөс нөгөө өнцөг хүртэл битүү өндөгтэй жаазнуудтай болох нь хаврын маллагааны гол зорилго юм. Жаазны зөвхөн төв хэсэгт л өндөгтэй олон жааз байснаас нэлэнхийдээ битүү өндөгтэй 2-3 жаазтай байх нь илүү ач холбогдолтой юм.

Зөгий өвөлжөөнөөс гарсны дараа хачигны эмчилгээ заавал хийнэ. Эмийг зааврын дагуу хэрэглэжгээе!

Зураг 4-3-5 Сархиаг дүүрэн өндөглөх




a) Хүчтэй болсон бүл
b) Жаазны өнцөг булан хүртэл өндөглөсөн байна.

4-4. Өвөлжөөнөөс гарснаас хойш нэг сарын дараагаас эхлэн хийх арчилгаа

4-4-1. Шинээр өндөглүүлэх жааз нэмэх

Нэг сар орчим өнгөрч хашлага самбарын гадна талын өндөглүүлэх нөөц жаазанд өндөглөж эхлэх үед (Зураг 4-4-1) тэр жаазыг дотогш нь оруулж захаасаа хоёр дахь байрлалд тавих ба түүний оронд хашлага самбарын гадна талд дахин шинэ жааз хийх ажлыг дахин давтах замаар жаазны тоог нэмсээр байна.



Зураг 4-4-1. Өндөглүүлэх

Энэ үед зөгийн бүлийн байдалд тохируулан шаардлагатай идэвхжүүлэх тэжээлээр тэжээж гаднаас амтат шүүс болон цэцгийн тоос хэрхэн цугларч байгааг шалгахын тулд 2-3 хоногт нэг удаа зөгийн бүлд үзлэг хийнэ.




Шахаад, идэвхжүүлэх тэжээл

Зөгийн бүлийн үзлэгийг тэд хоногийн зайтай хийнэ гэсэн тогтсон хугацаа байхгүй ба хэдийд юу хийх шаардлагатайг үзлэгийн дэвтэрт тухай бүр тэмдэглэж байх нь зөв юм.

Захын хоёр талын жаазанд бал хуримтлагдаж эхлэх ба үүнийг зөгий өндөг, үрвэлдэйгээ тэжээх энергийн эх үүсвэр болгон өөрсдөө иднэ.



Жааз нэмэхдээ өмнөх жаазнуудыг зөгий нэлэнхийд нь бүрхэж байгаа эсэхийг шалгана.



Өвөлжөөнөөс гарснаас 2 сарын дараа бал хураах бүл бий болгосон байх зорилт тавина. Үүний тулд зөгийг хавар маш сайн шахах шаардлагатай.

Энэ хүртэлх үйл ажиллагаа нь нарийн чимхлүүр тул боломжтой бол гэрийнхээ хашаанд, хол нүүхгүй хийх нь үр дүнтэй. Хоёроос гурван км дотор бургас ихээр цэцэглэсэн газарт бол бүр тохиромжтой юм. Хамгийн гол нь жааз дүүрэн битүү өндөг үрвэлдэйтэй болохыг зорих хэрэгтэй.

Өндөглөж эхэлснээс хойш 2 сарын хугацаанд
бал хураах зөгийн бүл бий болох явц

7 хоног	Өвөлжсөн зөгий	Өндөг, үрвэлдэй	Үүрэн доторх ажлын зөгий	Нислэгт гарна
1-дөх				
2-дөх				
3-дах				
4-дөх				
5-дах				
6-дах				
7-дөх				
8-дах				

Зураг: Yra Acara

Өндөглөж эхэлснээс хойш 3 долоо хоногийн дотор залуу зөгийнүүд ихээр бий болж удалгүй өвөлжсөн хуучин зөгийнүүд цөөрч 6 дах долоо хоногтоо шинээр гаднах ажлын (нислэгт гарах) зөгийнүүд олширч эхэлнэ. Зөгийн зохистой арчилгааг хийснээр 2 сарын хугацаа өнгөрөхөд хураах хүчтэй бүл бий болно.

Бал хураах хүчтэй бүл гэж юу вэ?

Сүргийн бүтэц тэнцвэржсэн (өндөг, үрвэлдэй, дотор болон гадна ажлын зөгий ихтэй) эх тусгаарлах тор тавьж давхарласан, залуу зөгий ихтэй бүлийг хэлнэ.

Гэтэл ...

Бүлийн тоог нэмэх, сүрэлгэхээс сэргийлэх зорилгоор 5 дугаар сарын сүүлээс 6 дугаар сарын эх хүртэлх хугацаанд бүл салгадаг зөгийчид байсаар байна. Энэ бол бал хураах хүчтэй бүлийг сүйтгэж буй хэрэг юм. Мөн сүрэлгэлээс сэргийлж буй муу арга юм.

Ийм болсон бүл нь давхар болтол хугацаа зарцуулна.

Давхарлаагүй бүл бол бал хураах бүл биш юм. Давхарлаагүй бүлийн захын хоёр жааз, ялангуяа өндөг, авгалдайтай жаазнаас 1-2 кг бал хураах нь ядарсан арга юм.


Балт зөгий амьдрах хугацаандаа нэг амны халбага цэцгийн шүүс цуглуулдаг байна. Ингээд бодохоор хэр олон гадна ажлын зөгий байж их хэмжээний бал цуглуулах нь ойлгомжтой буюу зөгийн бүлийн тооноос зөгийн тоо чухал гэдэг нь харагдаж байна.

Хүчтэй бүл!
Шинэ залуу зөгий
нэмэгдсээр ийм
шигүү зөгийтэй
болсон байх



4-4-2. Эх зөгийд өндөглөх ташаалавч нэмж өгөх

- Эх зөгий жаазны төвөөс зах руу тэлж өндөглөх ба ажилчин зөгий өндөглөсөн хэсгийг тойрсон ташаалавчнуудад цэцгийн шүүс хийж өндөглөх хэсгийг тэлэхэд саад болсон байдаг. Иймээс зөгийчин эдгээр цэцгийн шүүс бүхий ташаалавчнуудыг ховхчуураар хөнгөн эвдэж өгөхөд ажилчин зөгий тэднийг цэвэрлэдэг. Энэ үед эх зөгий тэдгээр цэвэрлэгдсэн ташаалавчинд өндөглөх боломж үүсдэг. Ийм байдлаар үзлэг хийх бүрдээ өндөглөх хүрээг бага багаар тэлсээр жааз дүүрэн өндөглүүлнэ.
- Энэ үйлдлийг голын 4-5 жаазанд байнга хийж байх шаардлагатай.
- Өндөглүүлэх хэсэгт шинээр бариулсан сархиагтай жааз болон өндөглүүлэхээр бэлтгэж байсан жаазыг тавьж өгөхөд нэлэнхийд нь цэцгийн шингэн шүүс хийгээд эхэлдэг. Энэ үед нь уг шүүсийг зөгийн дээр сэгерэн хоослоод тавихад зөгий дахин цэвэрлэж эх зөгий дүүрэн өндөглөдөг.



4-4-3. Зөгий сүрэглэх ба сэргийлэх арга хэмжээ

Зөгий сүрэглэх гэдэг нь эх зөгий хэсэг бүлэг ажлын зөгийн хамт үүрнээсээ явахыг хэлдэг бөгөөд ихэвчлэн хавар бүл хүчтэй болох үед тохиолддог. Бүл хүчтэй болохын хэрээр зөгийчний зүгээс зөгийн бүлд хийх арчилгаа нарийн чимхлүүр болж эх зөгий, ажлын зөгийд таатай нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай болдог. Шинэ эх зөгий бойжиж буй өлгийвч хаагдах үед хуучин эх зөгий бүхий хэсэг бүлэг ажлын зөгийнүүд сүрэглэдэг. Ихэнх тохиолдолд нийт ажилчин зөгийн 1/2–2/3 нь сүрэглэсэн байдаг. Японы зөгийчин Канно гуай “зөгий сүрэглэх нь зөгийчин хүний хувьд ичмээр явдал” гэж хэлж байсан. Энэ нь зөгий сүрэглэж болзошгүй шалтгааныг урьдчилан харж арга хэмжээ авч болно гэсэн үг юм.

Сүрэглэхийн өмнөх шинж тэмдэг:

- Сүрэглэх санамж бий болсон зөгийн бүлд жаазны доод хэсгээр торнивч, өлгийвч хэд хэдээр баригдсан байх
- Эх зөгийн дээгүүр ажлын зөгийнүүд давж алхах, эхийг тайван байлгахгүй байгаа шинж ажиглагдах
- Эх зөгийн бие өмнөхөөсөө жижгэрсэн харагдах (нисэхэд бэлэн болсон байх)
- Ихэнх ажлын зөгийнүүд үүр хайрцагны дотор, гадна ханаар дүүрэн сууж үндсэн ажлаа хийхээ болих

Зөгий сүрэглэх нөхцөл бүрдэх:

- Зөгийн бүл хүчтэй болохын хэрээр цэцгийн амтат шүүс, тоос нэмэгдэж эх зөгийд өндөглөх ташаалавч дутагдах
- Өлгийвчийг хянаагүйгээс шинэ эх зөгий гарах
- Хуучин эх зөгийн өндөглөх чадвар сулрах

Сүрэглэлтээс сэргийлж анхаарах зүйлс:

- Өлгийвч бий болохоос өмнө өндөглөх жаазыг тохиромжтой цаг хугацаанд нэмэх
- Өлгийвч барьж эхлэх үед өлгийвчтэй жаазыг цөөн зөгийтэйгөөр жижиг нуклэусд салгах, эсвэл устгах
- Зөгийн бүл хүч орж бал хураах бүл бэлтгэгдэж байх үед (7+1 жааз) давхарлах Энэ үед өлгийвч барьж эхэлбэл устгах шаардлагатай.
- Өлгийвчийг авах, устгах арга хэмжээ авах
- Эх зөгийг 1-2 жилд шинэчилж байх
- Хуучин боловч өндөглөлт сайтай эх зөгийн өрөөсөн далавчийг хяргана.

Сүрэглэл барихад анхаарах зүйлс:

- Сүрэглэл барихад шаардлагатай тагтай сав, уут, бээлий, торон малгай зэргийг бэлтгэнэ.
- Сүрэглэл барих үедээ эх зөгийг үлдээлгүйгээр авах
- Өндөрт байрласан сүрэглэлийг барих нь бэртэж гэмтэх аюултай тул орхих хэрэгтэй.
- Сүрэглэл барихын тулд мод тайрах зэргээр байгаль орчинд сөрөг үйлдэл хийхгүй байх



Сүрэглэсэн зөгийн бүл



Сүрэглэл барих үүр хайрцаг



Сүрэглэл барих уут

